



БАТЛАВ. МБСУТөвийн дарга
Ц.Батдорж



БАТЛАВ. БПК-ийн захирал
Г.Нямдулам

БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН НЭРЭМЖИТ "САНТЕХНИК
УР ЧАДВАР-2018" МЭРГЭЖЛИЙН БАГШ НАРЫН АНХ ДУГААР УРАЛДААНЫ
УДИРДАМЖ, ДААЛГАВАР

Уралдааныг зохион байгуулагч:

Барилгын политехник коллеж
Сантехникийн мэргэжлийн зөвлөл
"Өндөр бар" ХХК

Улаанбаатар хот 2018 он

Агуулга

Нэг. Уралдааны зорилго

Хоёр. Хамрах хүрээ

Гурав. Уралдаан болох газар, хугацаа

Дөрөв. Сантехникийн уралдааны нийтлэг шаардлага

Тав. Уралдаан явуулах журам

Зургаа. Уралдааны шаардлага, бэлтгэл ажил

Долоо. Уралдаанд оролцогчийн ажилбарт үнэлгээ өгөх, байр эзлүүлэх, дүгнэх

Найм. Ажлын даалгавар

Ес. Шаардлагатай багаж хэрэгсэл

Арав.Шагнал

Нэг. Уралдааны зорилго

Барилгын сайдаар олон жил үр бүтээлтэй ажилласан О.Тлейханы алдрыг мөнхжүүлэх зорилгоор барилгын политехник коллеж нь сантехникч мэргэжлийн багш нарынур чадварын уралдааныг цаашид жил бүр уламжлал болгон зохион байгуулах бөгөөд мэргэжлийн багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, туршлага солилцох, сантехникийн мэргэжлийн чадамжийн төвийн үйл ажиллагааг сурталчлахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Политехник коллеж, МСҮТ-ийн “Сантехникийн мэргэжлийн багш” нар

Гурав. Уралдаан болох газар, хугацаа

Уралдаан болох газар	Улаанбаатар хот, БГД 16-р хороо, Баруун 4 зам, Барилгын политехник коллеж
Уралдаан болох өдөр	2019 оны 03-р сарын 21, 22-ны өдөр
Техникийн зөвлөгөөн	2019 оны 03-р сарын 20-ны өдрийн 12:00 цаг
Уралдаан эхлэх болон дуусах цаг	09:00-18:00 /Цайны завсарлага 1 цаг /

Дөрөв. Сантехникийн уралдааны нийтлэг шаардлага

1. Техникийн зөвлөгөөн 2019 оны 03 дугаар сарын 20-ны 12:00 цагт БПК-ын 205 тоотод болно.
2. Нэг сургуулиас 1 багш оролцоно
3. Оролцогч нь туслахгүй байна.
4. Техникийн зөвлөгөөнд ирэхдээ оролцогч багшийн иргэний үнэмлэхийн хуулбар, 3x4 хэмжээтэй цээж зураг 1%, оролцооны төлбөрийг авчирна.
5. **Бүртгүүлэх хугацаа:** 2019 оны 03-р сарын 12-ны 18:00 цаг хүртэл <http://cc.edu.mn/registration> хаягаар хандаж онлайнаар бүртгүүлсэн байна. /Бүртгэлтэй холбоотой асуудлыг uuganbileg@cc.edu.mn цахим хаягаар болон Барилгын политехник коллежийн Сургалтын алба №201 тоотод хүлээн авна. Утас: 99044965/
6. Уралдааны оролцооны төлбөр 200.000 төгрөг байна. /Бэлнээр авчирна/
7. Уралдаанд оролцогч нь уралдааны техникийн баримт бичгийг /удирдамж/ мөрдөж ажиллахын зэрэгцээ шүүгч нарын шаардлагыг биелүүлж ажиллана.
8. Зөрчил гаргасан оролцогч шаардлага биелүүлээгүй тохиолдолд шүүгч нар ерөнхий шүүгчид мэдэгдэж тухайн зөрчлийг арилгуулах эрхтэй.
9. Ерөнхий шүүгч нь зөрчил гаргасан хүмүүст холбогдох арга хэмжээг авна.
10. Уралдаан болж буй хэсэгт чимээ шуугиангүй, хэрүүл маргаангүй нам гүм байвал зохино. Ямар нэг асуудал гарсан тохиолдолд оролцогч нь шүүгч нарт биеэр мэдэгдэнэ.
11. Шүүгч нарын зөвшөөрлөөр уралдааныг түр хугацаагаар зогсоож болох бөгөөд уралдааны хугацаа тооцогдсон хэвээр байх болно.
12. Бусад гадны хүмүүс тэмцээнийг тодорхой зайнаас ажиглаж сонирхохыг зөвшөөрнө.
13. Уралдааны шүүгчдийн бүрэлдэхүүн 100% ирцтэй байна.
14. Уралдаан тусгай дохиогоор эхлэнэ.
15. Оролцогчид уралдааны үеэр гар утсаа унтраана.

Тав. Уралдааныявуулах журам

Тэмцээний явуулах төрөл

Удирдамжийн дагуу урьдчилан бэлдсэн барилгын өрөө тасалгаанд дараах ажлыг гүйцэтгэнэ.

- Халаах хэрэгсэл суурилуулах, богино холбоос босоо шугам угсрах
- Халуун, хүйтэн усны шугамын угсралт хийх
- Ариутгах татуургын шугамын угсралт хийх

Зургаа.Уралдааны шаардлага, бэлтгэл ажил

1. Уралдаанд оролцогч нь хамгаалалтын хувцас өмсч, хувийн багаж хэрэгсэлээ бэлтгэсэн байна.
2. Оролцогч нь ажлаа эхлэхийн өмнө тухайн материал нь шаардлагад нийцэж буй эсэхийг шалгасан байх ёстой.
3. Угсрах тоноглол материалд ямар нэг өөрчлөлт орсон байж болохгүй бөгөөд зайлшгүй орсон тохиолдолд уралдааны ерөнхий шүүгч тухайн материал дээр цаашид ажиллаж болох эсэх талаар шийдвэр гаргана.
4. Уралдаанд оролцогч нар нь угсрах хоолой, материалыг тодорхой байрлалд, тодорхой хугацаанд угсарч бэлтгэнэ.
5. Шугам хоолой материалыг угсарч бэлтгэх үед түүнд ямар нэг гэмтэл учруулсан тохиолдолд түүнийг сольж өгөхгүй, харин оролцогч өөрөө засаж болно.
6. Шүүгч нар материалаа шаардлагын хүрээнд угсарч бэлтгээгүй хүнд түүнийг засаж хийх шаардлага тавина.
7. Уралдаан тусгай дохиогоор эхэлнэ. Оролцогч 10 мин ба түүнээс дээш хугацаагаар хоцорсон тохиолдолд уралдаанаас хасагдсанд тооцно.
8. Уралдаан явагдах хугацаа **4 цаг**

Долоо. Уралдаанд оролцогчийн ажилбарт үнэлгээ өгөх, байр эзлүүлж дүгнэх

Уралдааны шалгуур үзүүлэлтуралдааны өмнөх өдөр тавигдана.Уралдааны даалгаврын гүйцэтгэлийг үнэлэхдээ шүүгчид, уралдааны шалгуур үзүүлэлтэд заасны дагуу шалгаж үнэлгээ өгнө. Уралдааны шүүгч бүр шалгуур үзүүлэлтүүдийг дүгнэхэд оролцожнэгдсэн оноог тавина. Авсан онооны байдлаар цуваагаар байр эзлүүлнэ

Найм. Ажлын даалгавар

Удирдамжийн дагуу урьдчилан бэлдсэн тасалгаанд халаалтын системийн шугамын угсралтын ажилбар хийж гүйцэтгэнэ.












Халаалтын ажилбарыг хийж гүйцэтгэхдээ радиаторыг хананд бэхлээд салбар шугам, салбар шугам, босоо шугамыг зургийн дагуу холбоно. Бэлдэц хананд хэмжээс тавих














Халуун, хүйтэн усны шугамын угсралтыг өгөгдсөн зургийн дагуу хэмжээс тавьж угсралтын ажил гүйцэтгэх













Ариутгах татуургын шугамын угсралтыг өгөгдсөн зургийн дагуу хэмжээс тавьж, угсралтын ажил гүйцэтгэх




Ёс. Шаардлагатай багаж хэрэгсэл

Сантехникийн ур чадварын уралдаанд оролцогчдын хэрэглэх багажны жагсаалт

№	Багажны нэр	Тоо ширхэг	Тайлбар	Зураг
1	Пронцус	1	Аль нь ч байж болно	
		1		
2	Хэрээ хошуу	2		
3	Шруп мастер			
	Шруп мастер			
4	Төмрийн хөрөө	1		
5	Төмрийн хуурай	ком		
6	PVC хайч	1		
7	Ф50-100 PVC хоолой таслагч хайч, таслагч	1	Аль нь ч байж болно	
		1		
8	PVC гадна , дотор ам цэвэрлэгч	1		

9	Метр 5м	1		
10	Метр 2м	1		
11	Тэгш ус 1,2 м	1		
12	Тэгш ус 60 см	1		
13	Тэгш ус 30 см	1		
14	Φ15 PVC хоолой матагч /дотор/	1		
15	Φ15 PVC хоолой матагч /гадна/	1		
16	PVC хоолой матагч гар багаж	1		
17	Уртасгагч	1		
18	Өнцөг хэмжигч	1		
19	Харандаа	2		
20	Баллуур	2		
21	Цахилгаан гар тасдагч	1		

22	Отвертка + -	Ком		
23	Bit boxхошуу ком	1		
24	Төмрийн хөрөөний ир	3		
25	Тогтоогч өөрөө хийж ирэх зургийн дагуу	60	М10-10ширхэг, М8-50 ширхэгийг 2 мм-ийн листэн дээр 8,10-ийн гайк гагнаж хийх	   
26	Түлхүүрийн ком	1		
27	Нүдний шил	1		
28	Ажлын бээлий	1		
29	Шотка	1		
30	Клупп	КОМ		

31	Тооны машин	1		
32	Цаасны хутга	1		
33	Чихний бөглөө	1		

Арав. Шагнал

1-р байр нэг. Өргөмжлөл, мөнгөн шагнал

2-р байр нэг. Өргөмжлөл, мөнгөн шагнал

3-р байр нэг. Өргөмжлөл, мөнгөн шагнал

Тусгай байр нэг. Өргөмжлөл, мөнгөн шагнал

Бүх оролцогчдод батламж олгоно.

УРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС